



## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

### Г Ажлын хэсэг байгуулах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх, 48.7 дахь, 48.10 дахь хэсэг, Хуульчдын холбооны дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны Зөвлөлөөс ТОГТООХ нь:

3. Улсын Их Хурлаас 2013 онд баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан Монголын Хуульчдын холбоонд бүртгэлтэй хуульчдын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн мэдээлэх үргийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2022 оны 265 дугаар "Хөтөлбөр батлах тухай" (Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр) тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталсан "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийг хангах зорилгоор Хуульчдын холбооны гишүүн хуульчдын мэдүүлэх үргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, үнэлэх "Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх журмын төсөл" болон "Хяналт шалгалтын гарын авлагын төсөл" боловсруулах ажлын хэсэг байгуулахыг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч /П.Одгэрэл/-д даалгасугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Ерөнхийлөгч /П.Одгэрэл/-д, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг Тамгын газар /Ш.Жолбарс/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

П.ОДГЭРЭЛ

